










Monitoring Our Performance

July 2015

At Oyu Tolgoi we have made a commitment to operate our business in a safe and sustainable manner that delivers benefits to all our stakeholders. This scorecard is designed to help track our progress on various key parameters, including safety, environmental performance, procurement, employment and social contributions to Mongolia.




Манай ажлын үзүүлэлт

2015 оны 7 дугаар сар


“Оюу толгой” компани үйл ажиллагаагаа аюул ослоос ангид тогтвортой явуулж, оролцогч талуудад үр өгөөжөө өгөх үүрэг хүлээсэн билээ. Энэхүү үнэлгээний хуудсаар дамжуулан бид аюулгүй ажиллагаа, байгаль орчин, худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөрөнгө оруулалт зэрэг үндсэн чиглэлээр олж буй ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хүргэх болно.

Гэмтэл бэртэлгүй ажилласан өдрүүд (хоног)




“Оюу толгой” компани 2015 оны эхний хагаст 181 хоногийн 174 хоногт нь гэмтэл бэртэлгүй ажиллав. Гэмтэл бэртийн давтамжийн үзүүлэлт 0.22 байгаа нь Рио Тинто компанийн хэмжээнд хамгийн бага гэмтэл бэртэл тохиолддог, аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.

Монгол ажиллагсдын хувь хэмжээ (хувь)



2015 оны II улирлын эцсээр “Оюу толгой”-н нийт ажиллах хүчний 95 хувийг монгол иргэд бүрдүүлж байгаа бөгөөд тэдний 21.6 хувийг Өмнөговь аймгийн иргэд эзэлж байна.


Татвар, хураамж, бусад төлбөр (сая ам.доллар - сараар)



“Оюу толгой” компани 2014 онд 248 сая ам.долларын татвар, хураамж болон бусад төлбөрт төлсөн бол 2015 оны эхний хагаст 155 сая ам.доллар төлөөд байна.

* Өсөн нэмэгдсэн дүнд 30 сая ам.долларын татварын урьдчилгаа төлбөрийн суутган тооцоо багтсан болно.

Үндэсний худалдан авалт (сая ам.доллар - сараар)




2015 оны II улирлын байдлаар “Оюу толгой” компани нь 800 орчим ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласан бөгөөд тэдний 530 нь үндэсний компани юм. Үйл ажиллагааны худалдан авалтын зардлын 55 хувийг эдгээр компаниудад зарцуулав.

Усны зохистой хэрэглээ (тонн хүдэр боловсруулахад зарцуулсан шоо метр ус - сараар)




Ижил төрлийн зэсийн уурхайнуудын олон улсын дундаж үзүүлэлт

Ус дахин ашиглалт (хувь - сараар)



2015 оны эхний хагаст “Оюу толгой”-н баяжуулах үйлдвэрт нэг тонн хүдэр боловсруулахдаа дунджаар 0.43 шоо метр ус ашигласан. Зэсийн уурхайнуудын дэлхийн дундаж үзүүлэлт 1.2 шоо метр байдаг. Ус дахин ашиглалтын түвшин энэ хугацаанд 85.7 хувь байлаа.

Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт (сая ам.доллар - сараар)




2015 оны II улиралд Өмнөговь аймагт бүртгэлтэй 80 орчим ханган нийлүүлэгч “Оюу толгой”-д бараа, үйлчилгээ нийлүүлээ.

Боловсрол, сургалт



Олон улсын хөдөлмөрийн стандартад нийцсэн, чадварлаг боловсон хүчин бэлтгэх боловсрол, сургалтын хөтөлбөрүүд нь “Оюу толгой”-н тэргүүлэх чиглэлийн нэг хэвээр байна. 2015 оны эхний хагаст боловсрол сургалтын хөтөлбөрт 1.5 сая ам.доллар зарцуулав.

Орон нутгийн тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд



“Оюу толгой” компани тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд 2015 оны эхний хагаст 1.2 сая ам.долларыг энэ чиглэлд зарцуулав.

Дотоодод зарцуулагдсан нийт мөнгөн хөрөнгө 2010-2015 (2015 оны II улирлын байдлаар)



“Оюу толгой” ХХК 2010-2015 оны эхний улиралд Монголын компаниудтай худалдан авалт хийсэн дүн, Монгол улсын төсөвт байгууллагуудад төлж буй татвар хураамж, ажилчдын цалин зэргээр улсын хэмжээнд 4.97 тэрбум ам.доллар зарцуулсан. Монгол компаниудад хийсэн төлбөрт 89.2 гаруй сая ам.долларын боловсрол, сургалт, нийгмийн хөрөнгө оруулалтын зардлууд багтсан болно.